

ТӨГСӨЛТИЙН ДАРААХ БОГИНО ХУГАЦААНЫ ЦАХИМ СУРГАЛТЫН ПЛАТФОРМ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Үндэслэл

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, ЭМС-ын 2017 онд баталсан “Журам шинэчлэн батлах тухай” А/337 тоот тушаалын холбогдох заалтуудыг үндэслэн эмнэлгийн мэргэжилтэний мэдлэг, ур чадварыг тасралтгүй сайжруулах, хөгжүүлэх төгсөлтийн дараах тасралтгүй сургалт, багц цагийн богино хугацааны сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Коронавируст халдвар /COVID-19/-ын хөл хорио, халдвар хамгааллын дэглэмтэй холбоотойгоор багц цагийн богино хугацааны сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах зайлшгүй шаардлага тулгараад байгаа билээ.

2020 онд цахим сургалтын платформыг үйл ажиллагаандээ нэвтрүүлж хэрэглэгчийн бүртгэл болон цахим контент оруулах үндсэн 2 модулийг хөгжүүлэн 9 цахим контентийг оруулж 2877 хүнийг цахим сургалтанд хамруулсан. Гэсэн хэдий ч сургалтын модулуудын чанарыг сайжруулах, цахимаар суралцагчдын мэдлэг, чадварыг бодитоор үнэлэхэд шаардлагатай идэвхитэй хэлэлцүүлэг өрнүүлэх мэдээлэл солилцох, сургалтын агуулгын дагуу хичээлийн өмнөх болон дараах сорил бөглүүлэх, бие даалт оруулах үнэлэх, тайлан мэдээлэл гаргах талбаруудыг цахим сургалтын системдээ нэмэлтээр хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа юм.

“Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг Монгол Улсын хариу арга хэмжээ” төслийн хүрээнд нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чадавхийг сайжруулах сургалтын үйл ажиллагааг ЭМЯ, ДЭМБ-тай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Уг төслийн хүрээнд боловсруулсан сургалтын модулыг богино хугацааны багц цагийн сургалтын хэлбэрээр явуулахаар бэлтгэл ажлууд хийгдэж байна. Сургалтыг чанартай, үр өгөөжтэй явуулж, төслийг амжилттай хэрэгжүүлэхэд цахим сургалтын платформ ихээхэн ач холбогдолтой юм.

Зорилго

Европын Холбооны санхүүжилт, ДЭМБ-ын техникийн дэмжлэгтэйгээр хийгдэх нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чадавхийг сайжруулах сургалтыг цахим хэлбэрээр явуулахад шаардлагатай програм хангамжид удирдлага, мэдээллийн самбар, сорил, бие даалт, форум, цахим гэрчилгээ олгох зэрэг үйлдэлүүдийг хийх нэмэлт хөгжүүлэлт хийх

Зорилт

1. Цахим сургалтын програм хангамжийг хөгжүүлэх техникийн даалгаврыг боловсруулах
2. Цахим платформд нэмэлт хөгжүүлэлт хийх
3. Сургалтын материалыг цахим платформд оруулан суралцагчдад түгээх
4. Багц цагийн гэрчилгээг цахимжуулж эмнэлгийн мэргэжилтэний нэгдсэн бүртгэлийн сантай холбох
5. Туршилт сургалтыг зохион байгуулж системийн үнэлгээ болон эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүдийг мэдлэг, чадварыг үнэлэх